



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 07 өдөр

Дугаар №14

Савхуул

"3-р цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэх ажил"-ын шууд худалдан авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2017 оны "Орон нутгийн хөгжлийн сан"-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх "3-р цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэх ажил"-ын шууд худалдан авах комиссыг зөвшилцсөнөөр дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

КОМИССЫН ДАРГА:

Х.МӨНХЖАРГАЛ – Засаг даргын

Тамгын газрын дарга

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

Б.МӨНХЦЭЦЭГ – Хөрөнгө оруулалтын

мэргэжилтэн

ГИШҮҮН:

Ц.ПҮРЭВНЯМ – 3-р цэцэрлэгийн нярав

2. Худалдан авах ажлыг захиалагчаас гаргасан ажлын даалгаврын дагуу шаардлагад нийцсэн нийлүүлэгчтэй гэрээ байгуулан гүйцэтгэлийг хангуйж, акт үйлдэн холбогдох баримтыг хавсарган хүлээлцэхийг комиссын дарга /Х.Мөнхжаргал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

В. БАТ-ЭРДЭНЭ

